



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2026 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 4/95

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн дүрмийн 5.2 дахь хэсэг, 2.2.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Парламентын судалгаа шинжилгээ” эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өгөгдөл, дүн шинжилгээний хэлтэс (П.Түмэнцэцэг)-т даалгасугай.

3.Эрдэм шинжилгээний сэтгүүлийг хэвлүүлэх хөрөнгө, зардлыг тус хүрээлэнгийн жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Захиргаа, зохион байгуулалтын газар (Э.Цэнгүүн)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирлын 2025 оны “Журам батлах тухай” А/137 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОДХҮҮ



## ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ ЭРХЛЭН ГАРГАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар (цаашид "Тамгын газар" гэх)-ын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн (цаашид "Хүрээлэн" гэх)-ээс "Парламентын судалгаа шинжилгээ" эрдэм шинжилгээний сэтгүүл (цаашид "Сэтгүүл" гэх)-ийг эрхлэн гаргахтай холбогдох харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Сэтгүүлийн зорилго нь судалгаа шинжилгээ, баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хийгдсэн бүтээл, өгүүллийг нийтлэх, судлаачдын судалгааны үр дүнг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, мэдлэг, мэдээллийн солилцоог нэмэгдүүлэхэд оршино. Сэтгүүлийг үүсгэн байгуулагч нь Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн байх бөгөөд сэтгүүлийн нэрийг эзэмших эрх нь үүсгэн байгуулагчид хадгалагдана.

1.3. Сэтгүүл нь монгол хэлээр "Парламентын судалгаа шинжилгээ" эрдэм шинжилгээний сэтгүүл, англи хэлээр "Journal of Parliamentary Research and Analysis" гэсэн оноосон нэрийг хэрэглэнэ.

1.4. Сэтгүүлийг эрхлэн гаргах үйл ажиллагааг Хүрээлэн хариуцна.

1.5. Сэтгүүл шуудангийн болон цахим хаягтай байна. Сэтгүүлийн шуудангийн албан ёсны хаяг нь Хүрээлэнгийн хаяг, цахим шуудангийн хаяг нь "journal@prdi.mn" байна.

### Хоёр. Өгүүллийн бодлого

2.1. Сэтгүүлийн өгүүллийн бодлого нь парламент, хууль тогтоох үйл ажиллагаа, төрийн бодлого, эрх зүй, засаглал, ардчилал, нийгэм, эдийн засгийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийж, бодлогын санал, зөвлөмж дэвшүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллийг эмхэтгэн нийтлэхэд чиглэгдэнэ.

### Гурав. Сэтгүүлийн редакцын зөвлөл

3.1. Сэтгүүл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй редакцын зөвлөл (цаашид "Редакцын зөвлөл" гэх)-тэй байна. Шаардлагатай тохиолдолд 3 хүртэлх давхар хянан магадлагч гишүүн нэмэлтээр ажиллуулж болно.

3.2. Редакцын зөвлөл нь дарга, гишүүдээс бүрдэнэ. Редакцын зөвлөлийн дарга нь Хүрээлэнгийн захирал байна.

3.3. Редакцын зөвлөлийн гишүүд нь судалгаа, шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд ажилласан туршлагатай, тодорхой салбаруудаар мэргэшсэн эрдэмтэн, судлаачид байна.

3.4. Хянан магадлагч гишүүн нь тухайн чиглэлээр докторын зэрэгтэй байна.

3.5. Сэтгүүлийн Ерөнхий редактор нь Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн

дарга, Хариуцлагатай нарийн бичгийн дарга нь Хүрээлэнгийн сэтгүүл хариуцсан албан хаагч байна.

3.6. Редакцын зөвлөлийн бүрэлдэхүүн болон хянан магадлах гишүүнийг Хүрээлэнгийн захирлын тушаалаар томилж, чөлөөлнө.

3.7. Редакцын зөвлөл болон хянан магадлагч гишүүдэд урамшуулал олгож болох бөгөөд урамшууллын хэмжээг Хүрээлэнгийн захирлын тушаалаар тогтооно.

3.8. Редакцын зөвлөл дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ:

3.8.1. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн өгүүлэл нь энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, уг өгүүллийг нийтлэх эсэх талаар дүгнэлт гаргах;

3.8.2. Өгүүлэлд редакцын засвар хийх, эсхүл сайжруулах талаар зөвлөмж өгөх, шаардлагатай гэж үзвэл буцаах;

3.8.3. Сэтгүүлийн тухайн дугаарын сэдвийг тодорхойлох, өөрчлөх.

3.8.4. Хянан магадлагч гишүүн нь “Сэтгүүлд ирүүлсэн өгүүллийг мэргэжлийн түвшний хоёр талын магадлах (Double-blind peer review) аргаар хянаж, зохиогч ба хянагчийн мэдээлэл харилцан нууцлагдсан нөхцөлд хянана.

3.8.5. Хянан магадлагч гишүүн нь зохиогчоос хариу тайлбар өгөх боломжийг хангана.

3.9. Ерөнхий редактор нь эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавин ажиллана.

3.10. Хариуцлагатай нарийн бичгийн дарга дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ:

3.10.1. Сэтгүүл эрхлэн гаргах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

3.10.2. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн өгүүлэл нь энэ журмын 4.3, 4.4-т заасан шаардлагыг хангасан эсэхэд Хариуцлагатай нарийн бичгийн дарга эхний хяналт хийж, Редакцын зөвлөлийн гишүүнээр хянуулж, шаардлага хангаагүй өгүүллийг хүлээн авахаас татгалзах, засварлуулах, эсхүл зохиогчид буцаан сайжруулах ажлыг зохион байгуулах;

3.10.3. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн өгүүллийг хүлээн авч, 2-оос доошгүй редакцын зөвлөлийн гишүүнээр хянуулахаар хүргүүлэх;

3.10.4. Редакцын зөвлөлийн гишүүний хянаж ирүүлсэн өгүүллийг шаардлагад нийцүүлэн засварлуулах, сайжруулах арга хэмжээ авах;

3.10.5. Редакцын зөвлөлийн хурал зохион байгуулах, тухайн дугаарыг эрхлэн гаргахтай холбоотой Зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг хэрэгжүүлэх.

### **Дөрөв. Сэтгүүлд нийтлэх өгүүлэлд тавигдах шаардлага**

4.1. Сэтгүүлд энэ журамд заасан нийтлэг болон тусгайлсан шаардлагыг хангасан, өгүүллийн бодлогод нийцсэн өгүүллийг нийтэлнэ.

4.2. Сэтгүүлд ирүүлсэн өгүүллийг сэдэв, агуулгаас нь хамааруулан тодорхой салбар, дэд сэдвүүдэд хувааж байршуулна.

4.3. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн өгүүлэлд тавигдах нийтлэг шаардлага:

4.3.1. Өгүүлэл нь Монгол эсвэл Англи хэл дээр байна;

4.3.2. Гарчиг, зохиогчийн нэр, эрдмийн зэрэг, цол, байгууллага, эрхэлж буй албан тушаал нь монгол, англи хэлээр байх;

4.3.3. Өгүүлэлд ашигласан зургийг 300 dpi-аас доошгүй нягтралтай, .jpg, .jpeg, .png, .psd өргөтгөлтэй файлаар тусад нь ирүүлж, зохиогчийн цахим шуудан болон холбоо барих утасны дугаарыг хавсаргасан байх;

4.3.4. Өгүүллийн хэлбэр: MS Word (.docx) болон PDF (.pdf), үсгийн фонт: Arial, 11 pt, мөр хоорондын зай: 1.15, эшлэл: Arial 10pt, мөр хоорондын зай: 1 байх;

4.3.5. Өгүүлэл нь гадаадын болон дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өмнө нь хэвлэн нийтлэгдээгүй байх;

4.3.6. Зохиогчийн эрхийн зөрчилгүй байх;

4.3.7. Эшлэл, зүүлтийг стандартын дагуу тэмдэглэсэн, зүй бус хэллэг ашиглаагүй байх.

4.4. Өгүүлэл дараах бүтэцтэй байна:

а) гарчиг (монгол, англи хэлээр);

б) түлхүүр үгс (монгол, англи хэлээр);

с) хураангуй хэсэг (монгол, англи хэлээр);

д) үндсэн хэсэг;

е) дүгнэлт, бодлогын зөвлөмж;

ф) ашигласан ном зүй.

4.4.1. Өгүүлэл нь гарчиг, түлхүүр үгс, хураангуй, ашигласан ном зүй, хавсралтаас гадна 4000-6000 үгтэй байна.

4.4.2. Түлхүүр үгс нь 5 хүртэлх тооны холбоо үгээс бүрдэх ба өгүүллийн гарчигт ороогүй үгээс бүрдсэн байна.

4.4.3. Хураангуй (abstract) нь өгүүллийн агуулгыг ойлгомжтой байдлаар хураангуйлсан байх бөгөөд 150 хүртэлх үгтэй байна. Хураангуй хэсэгт өгүүллийн аль нэг хэсгээс шууд хуулбарлаагүй байвал зохино.

4.4.4. Үндсэн хэсэгт оршил, онолын үндэслэл, онол, арга зүй, судалгааны хэсэг, үр дүнг багтаах бөгөөд өөрийн биш санаа болон өгүүлбэрт эшлэл авсан байна.

4.4.5. Дүгнэлт, бодлогын саналыг бичихдээ үндсэн хэсэгт дурдаагүй шинэ санаа оруулахгүй бөгөөд асуудлыг шийдвэрлэх арга замыг санал болгосон байна.

4.4.6. Өгүүлэлд ашигласан эшлэл, ном зүйг APA 7th Edition стандартын дагуу бичнэ.

#### **Тав. Өгүүлэл хүлээн авах, хэвлэн нийтлэх, түгээх**

5.1. Сэтгүүлд өгүүлэл хүлээн авах зар түгээх, өгүүллийг хүлээн авах, эмхэтгэх, хэвлүүлэх, түгээх ажлыг тус сэтгүүлийн Хариуцлагатай нарийн бичиг хариуцна.

5.2. Сэтгүүлд өгүүлэл хүлээн авах зарыг Улсын Их Хурлын болон Хүрээлэнгийн албан ёсны цахим хуудаст байршуулах бөгөөд сэтгүүлийн хэвлэлийн эхийг бэлтгэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө олон нийтэд мэдээлнэ.

5.3. Өгүүллийг тухайн дугаар хэвлэгдэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө

хүлээн авч Редакцын зөвлөлд хүргүүлнэ.

5.4. Редакцын зөвлөлөөс шаардлага хангаагүй гэж үзсэн өгүүллийг сэтгүүлд нийтлэхгүй байж болно. Энэ тухай зохиогчид мэдэгдэнэ.

5.5. Өгүүллийн хяналтын хугацаа ажлын 21 хоног байна.

5.6. Өгүүлэл нь дараах шалгуур, оноогоор үнэлэгдэнэ. Үүнд:

5.6.1. Сэдвийн шинэлэг байдал - 20 оноо

5.6.2. Судалгааны арга зүй - 20 оноо

5.6.3. Онол, судалгааны суурь - 15 оноо

5.6.4. Бодлогын ач холбогдол - 15 оноо

5.6.5. Эшлэл, ном зүй - 10 оноо

5.6.6. Хэл найруулга, бичвэрийн соёл - 10 оноо

5.6.7. Ёс зүйн шаардлага хангасан байдал - 10 оноо

5.6.8. Дээрх шалгуур, оноогоор үнэлэгдсэн өгүүлэл 70 буюу түүнээс дээш оноо авсан хянан магадлагааны хуудас (Хавсралт 3), зохиогчийн гэрээгээр (Хавсралт 2) баталгаажсан тохиолдолд сэтгүүлд хэвлэнэ.

5.7. Сэтгүүлийг жилд нэгээс дээш удаа эмхэтгэн гаргана.

5.8. Шаардлагатай тохиолдолд сэтгүүлийн тусгай дугаарыг эрхлэн гаргаж болох бөгөөд ийнхүү гаргахдаа энэ журмын 5.2, 5.3 дахь хэсэгт заасан хугацааг баримтлахгүй.

5.9. Сэтгүүлийг хэвлэж тараах хуваарийг Хүрээлэнгийн захирлаар батлуулж мөрдөнө.

5.10. Сэтгүүлийн цахим хувилбарыг Хүрээлэнгийн цахим хуудсанд байршуулна.

5.11. Сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллийн ашиглалт, оюуны өмчийн эрхийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хамгаална.

5.12. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл бүрд DOI (Digital Object Identifier) дугаар олгож, Crossref олон улсын мэдээллийн санд бүртгэнэ.

### **Зургаа. Ёс зүйн шаардлага**

6.1. Зохиогч нь Монгол Улсын Үндсэн хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж, нийтэд тогтсон болон олон улсад мөрдөгддөг ёс зүйн шаардлагыг удирдлага болгоно.

6.2. Зохиогч ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ баталгаажуулах маягыг (Хавсралт 1) хавсаргах бөгөөд ашиг сонирхол гэдгийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид зааснаар ойлгоно.

[БАЙГУУЛЛАГЫН ТОЛГОЙ БИЧИГ ДЭЭР ХЭВЛЭХ]

Байршил: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

Сэдэв:

Ашиг сонирхлын зөрчилгүйг баталгаажуулах мэдэгдэл

Би \_\_\_\_\_

(овог, нэр)

Сэтгүүл өгүүлэл хэвлүүлэх зорилгоор энэхүү мэдэгдлийг гаргаж байна.

Баталгаажуулалт

1. Би одоогоор тухайн редакцын зөвлөл болон эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авах байгууллагын ажилтантай ашиг сонирхлын зөрчилгүй болохыг баталж байна.  
Ашиг сонирхлын зөрчил нь эдийн засгийн ашиг сонирхол, улс төр, гэр бүлийн харилцаа, хувийн ашиг, эсхүл холбогдох аливаа нөлөөллийн хэлбэрээр үүсэж болзошгүйг ойлгож байна.
2. Хэрэв төслийн хэрэгжилтийн явцад бодит, болзошгүй, эсхүл төсөөлөгдөх ашиг сонирхлын зөрчил үүсвэл, би тухай бүрд нь УИХТГ-ын дэргэдэх ПСХХ-н Редакцын зөвлөлийн даргад болон зохих байгууллагад нэн даруй бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

Баталгаажуулж гарын үсэг

\_\_\_\_\_  
Нэр

\_\_\_\_\_  
Гарын үсэг

\_\_\_\_\_  
Огноо

Нийтлүүлэхээр ирүүлсэн өгүүллийн нэр:

Өгүүллийн зохиогч: \_\_\_\_\_

Байгууллага/албан тушаал: \_\_\_\_\_

Би (бид) доорх нөхцөлүүдийг зөвшөөрч байна:

1. Энэ өгүүлэл нь өмнө нь өөр сэтгүүлд нийтлэгдээгүй бөгөөд дахин зэрэгцээ хэвлүүлэхээр илгээгээгүй;
2. Өгүүлэлд оюуны өмчийн зөрчил байхгүй;
3. Хүний өгөгдөл ашигласан бол зохих ёс зүйн зөвшөөрөл авсан;
4. Өгүүлэл нийтлэгдсэн тохиолдолд "Парламентын судалгаа шинжилгээ" сэтгүүлд нийтлэх эрхийг олгож байна;
5. Сэтгүүл CC BY-NC лицензийн дагуу өгүүллийг нийтлэхийг зөвшөөрч байна.

\_\_\_\_\_  
Зохиогчийн гарын үсэг

\_\_\_\_\_  
Огноо

Редакцын зөвлөлийн гишүүн: \_\_\_\_\_

Хянан магадлагаа хийж буй өгүүллийн сэдэв: \_\_\_\_\_

Хүлээн авсан огноо: \_\_\_\_\_

Хяналт хийсэн огноо: \_\_\_\_\_

№	Үндсэн шалгуур	Үндсэн оноо	Дэд шалгуур / үнэлэх үзүүлэлт	Дэд оноо
1	Сэдвийн шинэлэг байдал	20	1.1. Сэдэвт өгүүллийн гол агуулга товч тодорхой туссан эсэх	5
			1.2. Судалгааны асуудал, асуулт, зорилго нь тодорхой бөгөөд сэтгүүлийн чиглэлтэй нийцсэн эсэх	5
			1.3. Сэдэв өмнө судлагдсан бол дахин судлах үндэслэл, судлаачийн хөндөж буй судалгааны шинэлэг өнцгийг тодорхой тайлбарласан эсэх	5
			1.4. Шинэлэг санаа, онол/арга зүй/практикт оруулах хувь нэмэр нь тодорхой туссан эсэх	5
<b>Дэд шалгуурын онооны нийлбэр</b>				<b>20</b>
2	Судалгааны арга зүй	20	2.1. Судалгааны дизайн, арга зүй нь зорилго, зорилт, дэвшүүлсэн асуудалтай логик уялдсан эсэх	5
			2.2. Судалгааны объект, хамрах хүрээ, түүвэр/тохиолдол сонголт оновчтой тодорхойлогдсон эсэх	5
			2.3. Бодлого, хууль эрх зүйн баримт бичиг, гадаад орны туршлага/кейсийг сонгосон үндэслэл, харьцуулалтын хүрээ, шалгуур тодорхой эсэх	5
			2.4. Арга зүйн хязгаарлалт, найдвартай байдал, хүчин төгөлдөр байдлын асуудлыг тусгасан эсэх	5
<b>Дэд шалгуурын онооны нийлбэр</b>				<b>20</b>
3	Онол, судалгааны суурь	15	3.1. Сэдвийн судлагдсан байдал, онолын үзэл баримтлалыг дотоод болон олон улсын эх сурвалжтайгаар хангалттай тоймлосон эсэх	5
			3.2. Өмнөх судалгааны үр дүнг шүүмжлэлтэй харьцуулж, судалгааны хоосон зай болон өөрийн судалгааны байр суурийг тодорхойлсон эсэх	5
			3.3. Онол, судалгааны суурь нь судалгааны зорилго, асуудал/таамаглал, дүгнэлттэй логик уялдсан эсэх	5
<b>Дэд шалгуурын онооны нийлбэр</b>				<b>15</b>
4	Бодлогын ач холбогдол	15	4.1. Судалгааны асуудал нь бодлого, практик, нийгэм-эдийн засгийн хэрэгцээ шаардлагатай тодорхой холбогдсон эсэх	5
			4.2. Судалгааны үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж нь нотолгоо, өгөгдөл, шинжилгээний үр дүнд тулгуурласан эсэх	5
			4.3. Үр дүнг бодлого, байгууллагын практик, хэрэгжилтэд ашиглах боломж, хязгаарлалт, цаашдын чиглэлийг тодорхой тусгасан эсэх	5
<b>Дэд шалгуурын онооны нийлбэр</b>				<b>15</b>
5	Эшлэл, ном зүй	10	5.1. Агуулгад дурдсан эх сурвалж бүр текст дотор зөв эшлэгдсэн, текстэд эшлэгдсэн бүх эх сурвалж ном зүйд бүрэн орсон эсэх	5

			5.2. Ном зүй, эшлэлийн хэлбэр сэтгүүлийн шаардлага бичвэрийн стандартад нийцсэн, эх сурвалжууд найдвартай, сэдэвтэй шууд холбоотой эсэх	5
<b>Дэд шалгуурын онооны нийлбэр</b>				<b>10</b>
6	Хэл найруулга, бичвэрийн соёл	10	6.1. Өгүүллийн бүтэц, хэсгүүдийн дараалал, догол мөрийн логик холбоос, академик найруулга ойлгомжтой, нэг мөр эсэх	5
			6.2. Гарчиг, товчлол, түлхүүр үг, хүснэгт/зураг/схем/график, тоон мэдээлэл, дүгнэлт зэрэг хэлбэрийн бүрдэл шаардлага хангасан эсэх	5
<b>Дэд шалгуурын онооны нийлбэр</b>				<b>10</b>
7	Ёс зүйн шаардлага хангасан байдал	10	7.1. Ёс зүйн зөвшөөрөл, мэдээлэлтэй зөвшөөрөл, нууцлал, өгөгдлийн хамгаалалтын шаардлагыг зохих ёсоор тусгасан эсэх	5
			7.2. Ашиг сонирхлын зөрчил, санхүүжилт, зохиогчийн хувь нэмэр, плагиат/давхар хэвлэлт/өгөгдлийн үнэн зөв байдалтай холбоотой эрсдэлгүй эсэх	5
<b>Дэд шалгуурын онооны нийлбэр</b>				<b>10</b>
<b>НИЙТ ОНОО</b>		<b>100</b>		
<b>Шүүмжлэгчийн ерөнхий зөвлөмж</b>				
<b>Шүүмжлэгчийн санал</b>		<b>1. Хэвлүүлнэ 2. Засвар оруулсны дараа хэвлүүлнэ 3. Татгалзана</b>		

**Тайлбар:** Эрдэм шинжилгээний өгүүллийг шалгуур тус бүрээр дүгнэх бөгөөд харгалзах нүдэнд тохирох оноог тавина. Нийт 100 онооноос 70 буюу түүнээс дээш авсан оноо авсан тохиолдолд сэтгүүлд хэвлэнэ.

Үнэлгээний тайлбараа нэгтгэн дараах байдлаар ерөнхийд нь үнэлнэ үү /Ерөнхий үнэлгээ/:

Нийтлэлийн хураангуй, үндэслэл, үр дүнгийн талаар ерөнхийд нь үнэлнэ үү	
Судалгааны ач холбогдлын талаар ерөнхийд нь үнэлнэ үү	
Судалгааны сул тал, алдаа дутагдал болон сайжруулах шаардлагатай зүйлсийг тодорхойлно уу	<p>Судалгааны агуулгын талаар тодруулах, боловсронгуй болгох, дахин дүн шинжилгээ хийх, нэмэлт мэдээлэл оруулах зэргээр судалгааг сайжруулах шаардлагатай асуудлуудыг (үнэлгээний шалгуурын харгалзах дэс дугаарыг ашиглах, жишээ нь: 2.3-ыг дэлгэрүүлэх г.м) тодорхойлон жагсаана уу.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. ...</li> <li>2. ...</li> <li>3. ...</li> </ol> <p>Судалгаанд анхаарах шаардлагатай мэдээлэл, тоо баримт, эшлэл болон бусад хэлбэрийн шаардлагуудыг (үнэлгээний шалгуурын харгалзах дэс дугаарыг ашиглах, жишээ нь: 5.2-ын дагуу үгзүйн алдааг засах г.м) жагсаана уу.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. ...</li> <li>2. ....</li> </ol>

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

.....

*гарын үсэг*

.....

*/нэрийн тайлал/*